

ЕВРОПЫН ХОЛБООНООС МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТӨСӨЛ

“ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО БА ХҮНИЙ ЭРХ”

бага хурлын тайлан

2018 оны 1 дүгээр сарын 16

Монгол улсын Гадаад хэргийн яам, Улаанбаатар хот

2018/02/18

Тайлан бичсэн: Хенк Хулсоф, Манжаагийн Ичинноров



Төслийн санхүүжүүлэгч: Европын Холбоо

Хэрэгжүүлэгч байгууллага: Олон улсын зөлөхүүдийн баг- байгууллага ICE

Хамтран хэрэгжүүлэгч: STEM VCR-Тогтвортой хөгжил байгууллага

Хятад улсад суугаа Европын холбооны төлөөлөгчийн газрыг төлөөлж Олон улсын зөлөхүүдийн баг- байгууллага ICE-аас өргөн барьж буй тайлан

ICE - International Consulting Expertise

150, Chaussée de La Hulpe

B-1170, Brussels, Belgium

Tel: +32.2.792.49.05

Fax: +32.2.792.49.06

www.ice-org.eu



Энэхүү тайланд тусгасан мэдээлэл, агуулгыг зөвхөн Олон улсын зөлөхүүдийн баг ICE EEIG- байгууллага хариуцна.
--

ГАРЧИГ

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ	4
I. ТАНИЛЦУУЛГА.....	5
II. ХЭЛЭЛЦҮҮЛСЭН АСУУДАЛ, ЗӨВЛӨМЖ.....	8
A. НЭЭЛТИЙН ҮГ.....	8
Б. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ НЭГ “ЭРҮҮГИЙН ШИНЭ ХУУЛЬ: ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ”.....	12
Б.1. “Гэмт хэргийн зүйлчлэл болон Эрүүгийн хуультай холбогдон өөрчлөгдөн батлагдсан бусад хууль тогтоомжийн шинэчлэлийн асуудал”	12
Б.2. -“Ялын бодлого ба хүний эрх: Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн асуудал”	14
C. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХОЁР “ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ БА ХҮНИЙ ЭРХ”.....	15
C.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэл, өөрчлөлтийн асуудал”	15
C.2. “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дахь хүний эрхийн хэрэгжилт, сорилт, бэрхшээлүүд ”	17
Д. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ГУРАВ “ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛЬ БА ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО	20
Д.1. “Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах болон шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дахь олон улсын хүний эрхийн зарчим”	20
Д.2. Гэрч, хохирогчийг хамгаалах нь олон улсын хүний эрхийн чухал зарчим болох нь”	23
Д.3. “Эрүүгийн эрх зүйн тогтолцоо: Эрүүдэн шүүхийн эсрэг болон бусад хүний эрхийн конвенцийн хэрэгжилт”	25
Е. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ДӨРӨВ “ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО БА ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ НЬ”	27
Е.1. “Жендерт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа”	27
Е.2. “Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа”	28
Е.3. “Насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудал: Олон улсын стандарт”	30.
ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ	32
ЧИГЛҮҮЛЭГЧ БОЛОН ИЛТГЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГЧИЙН НЭРС.....	35

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУПХ	Олон улсын прокурорын холбоо
ЭШЭК	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц /Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц/
ЕХ	Европын холбоо
ХЕС +	Хөнгөлөлтийн ерөнхий систем +
ИБУТЭТП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ЭЗНСЭТК	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
ГХЯ	Гадаад харилцааны яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
АҮАҮБХУТОУП	Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц
ХЭТК	Хүүхдийн эрхийн тухай конвенц

I. ТАНИЛЦУУЛГА

Монгол улс 1990 онд ардчилсан хөгжлийн замыг сонгосоноос хойш эрүүгийн эрх зүйн тогтолцооныхоо шинэчлэлд анхаарсаар ирсэн билээ. Үүний үр дүнд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль болон Цагдаагийн байгууллагын тухай хуулиудад дорвитой өөрчлөлтүүд орсон. Түүнчлэн, хүний эрхийг хангах, хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэх Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг хуулиуд батлагдсан.

Монгол Улс хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагыг байгуулж, хүний эрхийн олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцуудыг баталсан нь энэ улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэлд чухал үүрэг гүйцэтгэсэн. Эрүүгийн эрх зүйн тогтолцоонд олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, стандартуудыг хэрэгжүүлэх үүргээ хүлээсэн хэдий ч амьдрал дээр өөрчлөлт, дэвшил удаашралтай явагдаж буй нь түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, хүн нөөц, туршлага дутагдалтай байгаатай холбоотой.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үйл ажиллагаа нь НҮБ-ын гэрээний байгууллагуудын анхааралд өртөхгүйгээр өнгөрөөгүй билээ. НҮБ-ын Хүний эрхийн хороон дээр хэлэлцсэн өмнөх жилийн тайланд эрүүгийн хуулиндаа эрүүдэн шүүхийн талаар тодорхойлолтыг бүрэн тусгаагүй асуудал, шүүн таслах үйл ажиллагаан дах авилга, хараат бус байдлын асуудал, таслан сэргийлэх цагдан хорих болон ялтанг тусгаарлан ганцаарчилж хорих үйл ажиллагааг ихээр хэрэглэж буйд санаа зовниж буйгаа илэрхийлсэн байдаг.

Ойрын саруудад улс төрийн хүрээнд хүчтэй яригдаж буй цаазаар авах ялыг дахин сэргээх зэрэг ухралт хийж болзошгүй алхамууд нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хийсэн шинэчлэлд саад учруулах юм. Эрүүгийн эрх зүйн тогтолцоон дахь шинэчлэлийн боломж болон бэрхшээлүүд нь Европын холбоо болон Монгол улсын Засгийн газрыг хамтран эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хүний эрхийг хэрэгжүүлэх асуудлаар цуврал гурван семинар, хурал зохион байгуулах сэдлийг өгсөн билээ. Европын холбооны Хамтын ажиллагааны баримт бичиг төслөөс санхүүжүүлэгдэж буй энэхүү цуврал семинарууд нь 2016-2020 он хүртэлх Монгол улс дахь Европын холбооны Хүний эрх ба ардчиллын Стратегийн санаачлага бөгөөд тус оронтой хийсэн хүний эрхийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, тус орны хувьд хүний эрхийн чиглэлээр олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлж буй алхам юм.

Олон улсын хүний эрхийн гэрээ, хэлэлцээр, конвенци бусад механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргах хүний эрхийн нийт гурван удаагийн цуврал семинар зохион байгуулахын зэрэгцээ Монгол улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын хүний эрхийн конвенцууд болон ОУХБ-ын гэрээнүүдийг орчуулахад дэмжлэг үзүүлэх, УЕПГ-ын чадавхийг дээшлүүлэх, Европын Холбооны улсуудад хоёр удаа шинжээчийн түвшиний аялал зохион байгуулах, Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Сургалт, судалагааны төвд хүний эрхийн чиглэлийн хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа хэрэгжих юм.

2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Монгол улсын Гадаад хэргийн яамны хурлын зааланд болсон энэхүү бага хуралд засгийн газрын болон иргэний нийгмийн нэр хүндтэй төлөөлөгчид болох 100 гаруй хүмүүс оролцож, тус улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоон дахь өөрчлөлт, шинэчлэлт болон бэрхшээлийн талаар санаа бодлоо солилцлоо.

Энэхүү нэг өдрийн арга хэмжээнд шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын төлөөлөл оролцсоноос гадна өмгөөлөгчид, эрдэмтэд, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон юм. Бага хурлыг нээж, Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга Д. Даваасүрэн, Хууль зүй дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г. Баясгалан нар Монгол улсын засгийн газрыг төлөөлж, Еврпын холбоог төлөөлж, тус улсад Монгол Улс дах Европын холбооны төлөөлөгчийн газрын хэргийг түр хамаарагч ноён Марко Ферри нар үг хэллээ.

Хэлэлцүүлэг дөрвөн үндсэн сэдвийн хүрээнд өрнөсөн. Хэлэлцүүлгүүд Эрүүгийн шинэ хууль болон түүнд хамаарах бусад хуулиудын хэрэгжилтэнд гарч буй хүндрэл бэрхшээлүүдийг тодорхойлж, эрүүгийн эрх зүйн тогтолцоонд оролцогчид эдгээр бэрхшээл саадыг хэрхэн засч залруулах талаар ярилцсан.

-Нэгдүгээр хэлэлцүүлэгийн сэдэв Эрүүгийн хуулийг хэрэглэхэд хүний эрхийн зарчим, олон улсын стандартыг хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээл болон ололтуудын талаар өрнөсөн юм. Гэмт хэргийн зүйлчлэл болон 2017 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн хэрэгжсэн шинэ Эрүүгийн хуультай холбогдон өөрчлөгдөн батлагдсан бусад хууль тогтоомжийн шинэчлэлийн асуудал болон эрүүгийн эрх зүйн шинэчлэл дэх ялын бодлого ба хүний эрхийн асуудлыг хэлэлцүүлсэн.

-Хоёрдугаар хэлэлцүүлэгт эрүүгийн процесс ба хүний эрхийн хэрэгжилт сэдвийн хүрээнд өрнөсөн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэл, өөрчлөлтийн асуудал болон эрүүгийн процесс дахь хүний эрхийн хэрэгжилт, сорилт, бэрхшээлүүдийн талаар ярилцсан бөгөөд эдгээр асуудлын хүрээнд мөрдөн шалгах үйл ажиллагаа, прокурорын үйл ажиллагаа, шударга

шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилт, эрүүдэн шүүх зэрэг бусад чухал асуудлуудыг хөндөн ярьсан.

-Гурав дахь хэлэлцүүлгийн хэсэг нь олон улсын эрх зүй ба хүний эрх гэсэн агуулгын хүрээнд өрнөсөн бөгөөд эрүүгийн хэргийг мөрдөн шалгах болон шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дахь олон улсын хүний эрхийн зарчим, гэрч, хохирогчийг хамгаалах олон улсын хүний эрхийн зарчим болон эрүүдэн шүүхийн эсрэг болон бусад хүний эрхийн конвенцийн хэрэгжилт зэрэг сэдвүүдийг хэлэлцүүлсэн.

-Дөрөвдэх хэлэлцүүлэгт эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлийн асуудалд анхаарлаа хандуулж, жендерт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа болон насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудал ба олон улсын стандарт сэдвүүдийг хөндөж, ярилцан, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Энэхүү тайланг бичигч нь аль болох дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг хичээж буй ч бүх хэлэлцүүлэг, санал бодол, яриануудыг бүгдийг тэр чигт нь багтаах боломжгүй болохыг дурдмаар байна. Харин хэлэлцүүлгүүдийн хүрээнд өрнөсөн чухал санаа оноог хураангуйлан тусгаж, оролцогчдын хэлсэн санаа бодлыг зөвлөмж, дүгнэлтэнд товчлон оруулсан болно.

Энэхүү төслийг хэрэгжүүлэгч хамт олны зүгээс Монгол улсын засгийн газар, тэр дундаа тус хурлыг зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлсэн Гадаад хэргийн яаманд талархалаа илэрхийлэхийг хүсч байна.



II. ХЭЛЭЛЦҮҮЛСЭН АСУУДАЛ, ЗӨВЛӨМЖ

A. НЭЭЛТИЙН ҮГ

“Эрүүгийн эрх зүйн тогтолцоо ба хүний эрх” сэдэвт бага хурлыг нээж Монгол улсын Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Д. Даваасүрэн, Хууль зүй дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г. Баясгалан болон Европын холбооны Монгол улс дахь төлөөлөгчийн газрын хэргийг түр хамаарагч Марко Ферри нар үг хэллээ.



Монгол Улсын Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Д. Даваасүрэн 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улс, ЕХ-ны Хамтарсан хорооны 17 дугаар ээлжит хуралдааны үеэр Хүний эрхийн асуудлаар хоёр тал анхны яриа хэлцээ (диалог)-н ач холбогдлыг өндөрөөр үнэлж буйгаа илэрхийлж, Монгол Улсад хүний эрхийг хангах, хамгаалах, эрх зүйт төрийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах, улмаар хоёр талын итгэлцэл, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх замаар Монгол Улс, ЕХ-ны түншлэл, хамтын ажиллагааг төгөлдөржүүлэхэд хувь нэмэр болно гэж үзэж буйгаа илэрхийллээ.

Монгол Улс, ЕХ-ны хооронд хийгдсэн хүний эрхийн асуудлаарх яриа хэлцээний бодитой нэг үр дүн бол 2017 оны 10 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн Монгол Улсад хүний эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл юм. Энэхүү төсөл нь: 1-рт: Монгол Улсад хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах, 2-рт: Монгол Улсын прокурорын байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд Монгол Улсын Гадаад харилцааны яам энэ төслийг хамтран хэрэгжүүлж байгаадаа баяртай байна.

Төслийн хүрээнд зохион байгуулж байгаа өнөөдрийн бага хурал нь Монгол Улс дахь эрүүгийн эрх зүйн шинэчлэл, олон улсын хүний эрхийн гэрээгээр хүлээсэн Монгол Улсын үүрэг хариуцлагатай хэрхэн нийцэж, уялдаж байгааг үнэлж, шийдвэрлэх асуудлыг тодорхойлоход ач холбогдолтой болно гэдэгт илтгэлтэй байна. Хууль хүн бүрт шударгаар үйлчилдэг байх, хэрэг зөрчлийг шийдвэрлэх бүх шатанд хүний эрхийг хүндэтгэдэг, хамгаалдаг байх нь нийгэмд шударга ёсыг тогтоох нэг гол зарчим бөгөөд хууль сахиулах байгууллагын төлөвшлийн хувьд мөн чухал шалгуур нь билээ. Нийгэмд шударга ёсыг бий болгох нь олон түмний сайн сайхан байдлын үндэс болохын хувьд өнөөдрийн бидний ярилцах асуудлын ач холбогдол өндөр, үр нөлөө нь гүн гүнзгий гэж үзэж байна.

Монгол Улс хүний эрхийн олон улсын 50 орчим гэрээнд нэгдэн орсон бөгөөд эдгээр олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах, дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх, гэрээний хэрэгжилтийн тайлан илтгэлийг цаг тухайд нь чанартай боловсруулж гэрээний хороодод хүргүүлэхэд Монгол Улсын Засгийн газар онцгой анхаарч ажиллаж байна. Монгол Улс хүний эрхийг хамгаалах олон улсын хамтын нийгэмлэгийн үйл хэрэгт хувь нэмрээ оруулахын төлөө бөгөөд 2016-2018 онд Хүний эрхийн зөвлөлийн гишүүний хариуцлагатай үүргийг гүйцэтгэж байгаа билээ. Хүний эрхийг дээдлэх, хамгаалах чиглэлээр Монгол Улс Европын Холбоо болон түүний гишүүн улс орнуудтай олон тал, мөн хоёр талаар хамтын ажиллагаагаа өргөжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа нотлохын хамт, Европын Холбооноос үзүүлж байгаа дэмжлэгт гүн талархал илэрхийллээ.



Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г. Баясгалан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудыг 2017 оны 5 дугаар сард Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталж, хуулиудыг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Эдгээр хуулиуд нь Монгол Улсын хариуцлагын тогтолцоог боловсронгуй

болгох, ардчилсан нийгмийн үнэт зүйл болох хүний эрх, эрх чөлөөг хангах, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэх хуулиуд юм хэмээн цохон тэмдэглэлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хорихоос өөр төрлийн ялыг өргөн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхээр хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн 15 орчим хувьд нь хорих ял оногдуулахгүй байхаар зохицуулж, гэмт хэргийн шинжтэй үйлдлээс бага хэмжээний хохирол учирсан тохиолдолд шууд гэмт хэрэгтэн болгохоор зааж ирсэн хатуу зохицуулалтыг өөрчилж зөрчилд тооцон хариуцлага хүлээлгэх зэргээр энэрэнгүй ёсны болон шударга ёсны зарчимд нийцүүлсэн олон дэвшилттэй өөрчлөлтүүд хийгдлээ. Манай улсын хариуцлагын тогтолцооны нэг хэсэг болох Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зөрчлийг гэмт хэргээс тодорхой үйлдэл, түүний шинжээр ялгамжтай зааглах үүднээс хүчин төгөлдөр үйлчилж буй 471 хуулийн 240 гаруй хуульд заасан захиргааны хариуцлага, түүнд хүлээлгэх торгууль, эрх хасах шийтгэлийг төрөлжүүлэн нэгтгэж, цаашид Монгол Улсад зөрчил, түүнд хүлээлгэх шийтгэлийг гагцхүү энэ хуулиар тодорхойлон шударга ёсыг тогтоож, нийгмийн хэв журам, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж байх болно хэмээв.

“Өнөөдрийг хүртэл зөрчил шалгах ажиллагаа нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулиас гадна салбарын хуулиуд, түүнийг дагаж байгууллагын хүрээнд

батлагдсан журмаар тогтоосон өөр өөр стандартаар хэрэгжүүлдэг байсныг өөрчилж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг зөрчил шалган шийдвэрлэх энэхүү ажиллагаанд хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн”. Түүнчлэн тухайн улсын эрүүгийн эрх зүйн тогтолцооны шударга байдал нь хууль зүйн тогтолцоо нь бүхэлдээ шударга эсэхийг үнэлэх шалгуур болдог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүний халдашгүй байх эрхийг хангах, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах, шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх зэрэг зарчмуудыг хэрэгжүүлэх үндэслэл, нөхцөл, журмыг тогтоосон болохыг дурдлаа.

Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийн зөрчил гаргахаас сэргийлж, дуу-дүрсний бичлэг хийх зэргээр орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглах журмыг тогтоож, хүний эрхийг хязгаарласан аливаа ажиллагааг зөвхөн шүүх, прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэхээр зааж, шүүхээс гадуур хүний эрхэд халдах хойшлуулшгүй үндэслэл, журмыг тодорхой тусгасан байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийн хууль ёсны эрхийг хангах шаардлагаар тодорхой зохицуулалтууд хуульд тусгагдсан. Тухайлбал, яллагдагчийн гэм буруутай эсэхийг урьдчилан тогтоох, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараагүй байхад гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж олон нийтэд мэдээлэхийг хориглох, яллагдагч хэргээ шүүхэд шилжүүлж хэлэлцүүлэхийг шаардах, энэ талаар гомдол гаргах эрхтэйг заасан тухай илтгэгч дурдав.

Энэхүү хууль мөрдөгдөж эхэлснээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр тодорхой ахиц гарч байгаа болно. Эдгээр хуулиудыг боловсруулах, хэлэлцүүлэх бүхий л үе шатанд салбар бүрийн бодлогыг анхаарч эрдэмтэн, судлаачид, мэргэжилтнүүд, салбарын байгууллагын төлөөллийг оролцуулах, тэдний санал, шүүмжийг ажлын хэсгээр хэлэлцүүлэн дэнсэлж шийдвэр гаргахад тус яамнаас нилээдгүй анхаарч ажилласан болохыг дурдаж, хурлыг зохион байгуулагчдад талархал илэрхийлэн, хурлын үйл ажиллагаанд амжилт хүслээ.

Европын холбооны Монгол улс дахь төлөөлөгчийн газрын хэргийг түр хамаарагч Марко Ферри Европын Холбоо нь Монгол улсад болон дэлхий даяар хүний эрхийг сурталчилан таниулах, хэрэгжүүлэх эрхэм зорилгын хүрээнд ажилладаг болохыг дурдаад олон улсын хүний эрхийн эрх зүйн актуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг сайжруулахад Монгол улстай хамтран ажиллах болсондоо баяртай байгаагаа илэрхийллээ. Монгол улс бол Хөнгөлөлтийн Ерөнхий систем гэсэн худалдааны нөхцлийн үр дүнг хүртэгч орон билээ. Уг



бүтцийн хүрээнд, хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжлийг дэмжих дэлхийн хамгийн өгөөмөр нэг талын худалдааны давуу талуудыг хангаж өгдөг юм. Жишээ нь нэхмэл/сүлжмэл эдлэлийг багтаагаад, маш олон төрлийн бүтээгдэхүүнүүдийг хамруулсан гаалийн тариф ногдохуйц бүтээгдэхүүний бараг 66%-хувийнх нь гаалийн татварыг бүрэн чөлөөлсөн гэсэн үг. Тавьсан нөхцөл нь ийм болохоор, Монгол улс нь, хүний үндсэн эрх болон хөдөлмөрийн эрхийн конвенциудыг (мөн байгаль орчныг хамгаалах, сайн засаглалыг дэмжих) багтаасан нийт 27 олон улсын конвенциудыг үргэлжлүүлэн баталж, үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг хангаж ажиллах юм.

“Хүний эрхийн талаар бидний Монгол улстай хамтарч буй хамтын ажиллагаандаа, хууль дээдлэх ёсыг хөхүүлэн дэмжих, иргэний нийгмийн байгууллагыг хөгжихөд нь дэм үзүүлэх, үндэсний хэмжээнд болон хөдөө орон нутагт нийгмийн эмзэг бүлгүүдийг чадавхжуулах арга хэрэгслийг хангаж өгөх, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг дэмжсэн нийтийн үйлчилгээг засварлан сайжруулах үр дүнтэй механизмын хүртээмжийг хангаж өгөх зэрэг асуудалд ЕХ анхааран төвлөрч байна. Монголын талаас, Олон улсын Хүний эрхийн эрх зүйн актуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх, мөн түүнийг Монголын үндэсний хууль тогтоомжуудад уялдуулах асуудлыг хангах тал дээр ЕХ-г хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг хүссэн юм. Уг хүсэлтийн бодит үр дагавар бол энэ семинар билээ.

Хүний эрхийн 3 цуврал хурлуудыг ийнхүү дэмжихийн зэрэгцээ ЕХ нь холбогдох олон улсын хүний эрхийн конвенцуудыг Монгол хэл дээр хүртээмжтэй болгох тал дээр хувь нэмэр оруулан ажиллах болно. Гэхдээ эдгээр нь зөвхөн дан ганц хурлууд биш байх болно. Бид мөн Монгол улсын Ерөнхий Прокурорын газрын болон Сургалт, судалгааны төвийн багш, судлаач, прокуроруудаас ЕХ-ны улсуудад 2 удаагийн шинжээчийн түвшний эрх зүйн зохицуулалтын яриа хэлэлцээний туршлага судлах аялалд оролцоход нь дэмжлэг үзүүлэх болно” гэлээ.

Б. НЭГДҮГЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

“ЭРҮҮГИЙН ШИНЭ ХУУЛЬ: ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ”

Б.1. “Гэмт хэргийн зүйлчлэл болон Эрүүгийн хуультай холбогдон өөрчлөгдөн батлагдсан бусад хууль тогтоомжийн шинэчлэлийн асуудал”



“Гэмт хэргийн зүйлчлэл болон Эрүүгийн хуультай холбогдон өөрчлөгдөн батлагдсан бусад хууль тогтоомжийн шинэчлэлийн асуудал” сэдвээр Улсын Ерөнхий Прокурорын Газар, Сургалт Судалгааны Төвийн багш, судлаач, хяналтын Прокурор Г. Оюунболд илтгэл тавьсан. 1992 оны Үндсэн хуулиар баталгаажсан үнэт зүйлүүдийг хамгаалах

зорилго бүхий эрүүгийн багц хуулийг баталсанаас хойш зургаан сар өнгөрч байна. Үндсэн хуулинд тусгагдсан хүний эрх, хувь хүний эрх чөлөө, өмчийн эрхийг хуулиар хангах, хамгаалах учиртай билээ. Эрүүгийн хуулийн шинэчлэл нь юуны өмнө эрүүгийн эрх зүйн системд хүний үндсэн эрхийг хангах, Үндсэн хуулийн үнэт зүйлийг хамгаалах дэлхий нийтийн хандлагыг Монголын хөрсөнд буулгах зорилготой. Хоёрдугаарт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд цагдан хохироос өөр төрлийн ялын системийг хөгжүүлэх, сэжигтэн, яллагагчтай харилцах харилцааг өөрчлөх зорилготой. Гэмт хэргийн улмаас нийгэм, хүнд учруулсан хохиролд тохирсон ялын бодлогын системийг хөгжүүлэх нь чухал юм. Түүнчлэн, энэхүү хуулинд гэмт хэрэгт тооцох шинэ төрлийн гэмт хэргийн зүйлчлэлийг тусгах шаардлагатай болсон. Шинэ эрүүгийн хууль шударга ёсны зарчим болон хууль шүүхийн өмнө тэгш байх зарчимд тулгуурлаж буйг онцлох хэрэгтэй.

Түүнчлэн илтгэгч нь цааш хэлэхдээ “тухайн улс оронд нь цаазаар авах ял болон эрүүдэн шүүх үйл ажиллагаа хэрэгждэг бол иргэнийг шилжүүлж өгөхгүй байх хуулийн хамгаалалтын зохицуулалтыг хийсэн нь хүний эрхийн тал дээр хийсэн бас нэгэн дэвшилтэт алхам юм. Мөн ялын хөнгөрүүлэх нөхцөлүүдийг тусгасан. Үүнд: анх удаагаа гэмт хэрэг үйлдсэн, хохирогчид эрүүл мэндийн болон бусад туслалцаа үзүүлсэн, дарамт шахалтын дор гэмт хэрэг үйлдсэн, хохирогчийн хууль бус болон буруутай үйл ажиллагаанаас болсон, хэргийн талаар хууль хяналтын байгууллагад өөрөө мэдээлэл өгсөн, байнгын зодуур, дарамт, хүчирхийлэлээс үүдэн өөрийгөө хамгаалах үйлдэл хийсэн зэрэг үйлдлийг тусгасан. Эрүүгийн хуулийн шинэчлэл нь уг салбарт ноёлж байсан яллах бодлогоос илүү хүмүүжүүлэх

бодлого руу шилжих, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад чиглэсэн болно.” гэв.

Эрүүгийн хэргийн зүйлчлэлд анхаарч хувь хүний эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг хамгийн түрүүнд оруулж өгсөнөөрөө онцлогтой. Хуучин хуулиар төрийн эсрэг гэмт хэрэгт илүү ач холбогдол өгч, гэмт хэргийн зүйлчлэлийн дарааллын эхэнд тавьж байсан билээ. Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эсрэг гэмт хэрэг зэрэг гэмт хэргийн шинэ төрлүүд шинээр тусгайлан зүйлчлэгдэн орж ирсэн нь хүний эрхийг хамгаалах, хангах чиглэлд гарсан чухал өөрчлөлт гэдгийг дурдах нь зүйтэй гэв.

Уг сэдвийн хэлэлцүүлэгт оролцож саналаа хэлсэн оролцогчид тус хуулийг практикт хэрэглэхэд олон саад бэрхшээл учирч буйг онцлоод ойлголтын зөрүү, өөрчлөлтүүдийг хэрхэн хэрэглэх, хэрэгжүүлэх удирдамж, сургалт дутагдалтай байгааг дурдаж байлаа. Зарим өөрчлөлтүүдийг ойлгох, тайлбарлах асуудалд бэрхшээл байгааг ярьж байлаа. “Гэмт хэргийн зүйлчлэл болон Эрүүгийн хуультай холбогдон өөрчлөгдөн батлагдсан бусад хууль тогтоомжийн шинэчлэлийн асуудал” сэдвээр илтгэл тавьсан Улсын Ерөнхий Прокурорын Газар, Сургалт Судалгааны Төвийн багш, судлаач, Хяналтын Прокурор Г. Оюунболд “шинэ хуулийг хэрэглэхэд гарч буй хамгийн том саад бэрхшээл бол хуульчдын сэтгэлгээний хоцрогдлын асуудал, ёс зүйн хөгжил, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчдийн хуучин ажлын хуучин арга барил” гэдгийг онцоллоо.

Оролцогчдын зүгээс хүний эрхийг хангах олон улсын зарчмуудыг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх ийм төрлийн сургалт, хурал, хэлэлцүүлгүүдийг хуульчдын дунд олноор зохион байгуулах шаардлагатай байгааг илэрхийллээ. Эдгээр өөрчлөлтүүдийг олон нийтэд сурталчлан таниулах болон энэ чиглэлд ажиллах хүмүүсийн чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагаанууд зохион байгуулагдах шаардлагатай байна.



Б 2. Ялын бодлого ба хүний эрх: Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн асуудал

МУИС–ийн Хууль зүйн сургуулийн профессор, доктор (Ph.D) Д.Баярсайхан ялын бодлого ба хүний эрхийн асуудлаар илтгэл тавьлаа. Хүний эрхийн үнэт зүйлсийг эрүүгийн эрх зүйгээр тууштай хамгаалах шаардлага өсөн нэмэгдсээр байгаа нь ялын бодлогод хүнлэг ёсны хандлага улам гүнзгий тусгагдах болсноор илэрч байна. Хүний амьд явах, нийгэмтэй харилцах, итгэл үнэмшилтэй байх, нэр төртэй байх, өөрийгөө хамгаалах эрх нь ял оногдуулах төдийгүй яллах чиг үүрэг хэрэгжүүлэх ямар ч үед хэзээ ч хязгаарлагдаж, хасагдах ёсгүй.

Цаазаар авах ялыг дэлхийн улс орнуудын нэлээд нь халж, түүнийг хэрэглэхгүй байх эрх зүйн орчныг бий болгосоор байна. Энэ нь нэг талаас хүний амьд явах, аюулгүй амьдрах эрхийг хангах үүргээ биелүүлээгүйгээс төр нь өөртөө хариуцлага хүлээж хохирогчийн гэр бүлд нөхөн төлбөр олгох шаардлагыг хангахад чиглэгддэг бол нөгөө талаас хүний амьд явах нь угаасаа хүний жам ёсны халдашгүй эрх болдгоор тайлбарлаж болно. Орчин үед “амийг амиар”, “цусыг цусаар” тооцох эрт үеийн талеоний систем үеэ өнгөрөөсөн төдийгүй орчин үед ялын зорилго нь эзнээ олсон, үр дүнтэй байх төдийгүй урьдчилан сэргийлэхэд илүү чиглэгдэх болсон байна.



Монгол Улсад эрүүгийн хууль шинэчлэгдэж, ялын бодлого нааштайгаар өөрчлөгдөх хандлага тавигдаж, хорих ялын хэт түгээмэл хэрэглээ илтэд хязгаарлагдаж, эрүүгийн эрх зүйн шинэ орчин бүрэлдэж байна. Гэвч монголын эрүүгийн процессын практикт яллах сэтгэлгээ давамгайлж,

яллах баримт сэлтийг хэт үнэлснээр нотолгооны тэнцвэрт зарчмыг алдагдуулах, мэтгэлцээний бус шүүх хуралдааны тогтолцоо зэрэг нь яллах ажиллагаа болон ялын бодлогод хүний халдашгүй эрхийг зөрчих, зүй бусаар хязгаарлах нөхцлийг аяндаа бүрдүүлсээр байгаа нь анхаарал татаж байна. Цаашдаа ялын бодлогод хүний эрхийн зарчим шаардлагад нийцсэн уян хатан, оновчтой, үр дүнтэй зохицуулалтыг бий болгох, хорихоос өөр төрлийн ялын төрлийг олшруулж, сонгох боломжтойгоор хуульд өөрчлөлт оруулах, эрүүдэн шүүлтээс ангид байх эрхийг бүх талаар баталгаатай хангах, монголын нийгэм, үндэсний онцлогт тохирсон ялын зохистой, тогтвортой орчныг бий болгох зэрэг тулгамдсан асуудалд анхаарах шаардлагатай байна. Хоригдож буй хүнд эрүүл мэндийн болон сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээнд дэвшил гаргах хэрэгтэй

С. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХОЁР “ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ БА ХҮНИЙ ЭРХ”

С.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэл, өөрчлөлтийн асуудал



Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвийн дарга Б.Бат-орших “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэл, өөрчлөлтийн асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлээ. Тэрээр

хэлэхдээ “Бидний хамгийн их шүүмжлүүлдэг зүйл бол хуучин хуулиар гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааг зөвхөн байцаалтаас өөр мөрдөн шалгах арга хэрэгсэл ашиглахгүй байна ” гэдэг асуудал байсан. Тиймээс бид эрүүгийн ЭХХШТХ-ийг шинэчлэх үеэр хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааны олон төрлийн арга барилыг нэвтрүүлэх тал дээр онцгой анхаарал хандуулж ажилласан. Бид хэрэг бүртгэлт болон мөрдөн байцаалт гэдэг нэр томьёог хэрэглэхээс зайлсхийх чиглэлийг барьсан. Тиймээс хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаа, тактик, арга барил зэрэг нэр томьёог илүүтэй хэрэглэх нь зүйтэй гэж үзсэн.

Өмнөх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль сэжигтэн, яллагдагчийг хохирогчийн буруутгал, хардалтанд үндэслэн эрүүгийн хариуцлагад татах боломжийг бүрдүүлсэн байсан. Тэгвэл одоо хуулийн шинэчилсэн найруулгаар эрүүгийн хэрэг үйлдэгдсэн баттай нотлох баримт, материал, фактад үндэслэн, эдгээр нь хуулийн шаардлага хангаж буй тохиолдолд сэжигтэн, яллагдагч хэмээн тооцдог болж буй юм. Зөвхөн ийм тохиолдолд л сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих боломж бүрдэх юм. Эрүүгийн хэргийг хянан шалгаж эхэлсэний дараа гэрчүүд мэдүүлгээсээ буцах, мэдүүлгээ өөрчлөх зэрэг хүндрэлүүд бий болдог. Энэ нь хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаанд саад учруулж, хэргийн үнэн мөнийг тогтооход хүндрэл учруулдаг. Хэргийн гол гэрчид нөлөөлөх дарамт шахалт байдаг

учраас үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэрчийг хамгаалах зохицуулалтуудыг оруулж өгсөн.

Хуучин хуулийн зохицуулалтаар бол хэн нэгэн этгээд 100 ширхэг зүйл хулгайлсан байлаа гэж бодоход хэргийн бүх фактыг тогтоохын тулд ямар ч хязгаарлалтгүйгээр, хугацаагүйгээр ажилладаг байсан. Шинэчлэлийн үйл явц үүнд анхаарлаа хандуулж, илүү хурдтай ажиллах шаардлагыг бидэнд тавьсан. Тиймээс үйлдэл тус бүрээр тусгаарлан, хурдан шуурхай шүүхэд хүргэгдэх боломжоор хангагдаж байгаа. Урд нь зарим хэрэг ийм шалтгаанаар 10 жил хүртэл үргэлжилдэг тохиолдол байсан. Хэрэг бүртгэлтийн явцад эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх хууль зүйн үндэслэл байхгүй болсон. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим хугацааг богино болгосон.

Эрүүгийн хуульд заасан хөнгөн хэргийн мөрдөн байцаалт 14 хоног, хүнд гэмт хэргийн мөрдөн байцаалт 1 сар, сэжигтнийг баривчлах 48 цаг, цагдан хорих үндсэн хугацаа 1сар, цагдан хорих хугацааг 24 сар хүртэл сунгах зэрэг зохицуулалтууд хийгдсэн. Судалгаагаар хорих ял эдлүүлэх, цагдан хорих арга хэмжээ өмнөх нөхцөл байдлаас 3 дахин багассан гэсэн судалгаа гарсан.

Мөн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ялладагч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа зөвшөөрч, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг прокурорт гаргах боломжтой болсон. Хүсэлтэд хохирлоо нөхөн төлсөн баримт, нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн тухай баталгаа гаргана. Прокурор үндэслэлтэй гэж үзвэл хэргийн зүйлчлэл, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаарх саналыг ялладагчид танилцуулж, зөвшөөрвөл гарын үсэг зуруулж, яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд шилжүүлнэ. Шүүх хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл тогтоогдвол гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасныг баримтлан прокурорын саналын хүрээнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Харин Эрүүгийн хуулийн Тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй.

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нууц байна. Хавтаст хэрэгт тусгагдаагүй баримт сэлт, мэдээлэл, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, бусад баримт болон гүйцэтгэх ажилтай холбоотой ямар ч баримт мэдээллийг шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах, хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд танилцуулахыг хориглоно.

Прокурор, шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах, нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаарх мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох, шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох, гэрч хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах зэрэг гэрч хамгааллын зохицуулалтуудыг оруулж өгсөн.

Шинэ хуулийн дагуу хэрэг анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдэгдсэн тохиолдолд прокурорт дахин мөрдөн байцаалтанд буцаахгүй болсон. Тиймээс хэргийг мөрдөн шалгахад бүрдүүлсэн материал, нотлох баримт, мөрдөн шалгах ажиллагаа, прокуроын үйл ажиллагааны хүрээнд шүүх дээр бүрэн шийдэхээр зохицуулсан.

Хуралд оролцсон өмгөөлөгч, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтнууд шинэ хуулийн зохицуулалтуудыг нэг мөр ойлгох, хэрэглэхэд гарч буй хүндрэлүүд нь ойлголтын зөрүү, нэгдмэл ойлголт бүхий сургалт дутагдаж буйгаас энэ хуулийг практикт хэрэглэхэд хүндрэл учирч байгааг илэрхийлэхийн сацуу зарим оролцогчид энэ хуулийн өөрчлөлтүүдийн заримыг Монголын хөрсөнд буулгах боломжгүй гэдгийг дурдсан сонирхол татаж байсан юм.

С.2. “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дахь хүний эрхийн хэрэгжилт, сорилт, бэрхшээлүүд ”

Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын дарга, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Батзориг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дахь хүний эрхийн хэрэгжилт, сорилт, бэрхшээлүүд ” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

Үндсэн хуулиар хүний эрхийг хамгаалдаг. Энэхүү чухал үнэт зүйлийг олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, прокурорын нийгэм дэх нэр хүндийг өсгөх замаар шийдвэрлэх боломжтой. Иймээс эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэл явагдаж буй нь чухал ач холбогдолтой юм. Хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөх магадлал маш өндөр байдаг. Прокурор хэргийг хянаж шүүхэд шилжүүлнэ. Оролцогчид хэрэгтэй гэж үзсэн нотлох баримт материалуудаа гаргаж өгнө. Гэрчүүд бас нотлох баримтууд гаргаж өгнө. Ийм маягаар шүүхэд шилжүүлсэний дараа ч нотлох баримтууд шинээр авагдах үйл явц өрнөж, хэргийг шүүн таслах процесст удаашрал үүсдэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ийм боломжийг хааж, хянан шийдвэрлэх хугацаанд тодорхой хязгаарыг тогтоож өгсөн.

Энэ хууль өмнө нь гурван удаа шинэчлэгдэж өөрчлөгдөж байсан. Гэхдээ энэ удаагийнх шиг хэргийг хянан шийдвэрлэх хугацааг шуурхай болгосон өөрчлөлт байгаагүй. 2009 оны нэмэлт, өөрчлөлтөөр хохирогчийн эрхийг хамгаалах, сэжигтэн, яллагдагчийн эрхийг хэрэгжүүлэх заалтууд орсон.

Өмнө нь бол гэрчийг хэрэг илрүүлэхэд тустай нотлох баримтын хэмжээнд авч үздэг байсан. Харин энэ хуулиар гэрчийг хэргийн бусад оролцогчдын адил авч үзэж, аюулгүй байдлаа хамгаалуулах эрхээр хангах механизмыг суулгаж өгсөн.

Хуулийн салбарын мэргэжилтнүүдийн өмнө энэхүү шинэ хуулийг амьдрал, практикт хэрэглэхэд олон тооны хүндрэл, бэрхшээлүүд үүсч байгааг дурдах нь зүйтэй. Парламентаар хууль батлагдсанаас 43 хоногийн дараа хууль үйлчилж эхэлсэн. Урд өмнө нь хууль батлагдсанаас 9 сарын дараа үйлчилж эхэлдэг туршлага байсан. Энэ нь хуульчдыг энэ хуулийг хэрэглэхэд мэдлэгжүүлэх, сургах зэрэг бэлтгэл хангагдах, иргэдийг боловсруулах, мэдлэгжүүлэх боломжит цаг хугацааг олголгүйгээр маш богино хугацаанд хуулийг хэрэглэх байдалд хүргэсэн нь учир дутагдалтай юм. Одоо эрүүгийн эрх зүйн тогтолцооны оролцогчид энэ хуулийг өөр өөрийн ойлгож буйгаараа хүлээн авах, тайлбарлах, хэрэглэх зэрэг байдал гарч байна. Цагдаа, прокурор, шүүгчид энэ хуулийн зарим заалтуудыг хэрхэн хэрэглэх, шийдвэр гаргах талаар өөр өөрийн удирдлагаасаа асууж, тодруулах замаар л хэрэглэж байна.

Мөрдөн байцаагч хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаандаа байнга прокуророос асууж, лавлах, тодруулах шаардлага гарч байна. Хуулийн агуулга, философи, үнэт зүйл овронгоороо өөрчлөгдсөнд хамаг учир байгаа юм. Тийм учраас хуучин сэтгэлгээ, хандлага нь өөрлөлтүүдийг хүлээн авах, энэ хуулийг хэрэглэхэд төвөг учруулж буй гэдгийг онцлох хэрэгтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэхэд алдаа гаргадаг шалтгааныг судалсан судалгаанд хариулагчдын 94 хувь нь “хуулийн талаар хангалттай сургалт хийгдээгүй”, 77 хувь нь “хуулиа судлаагүй”, 48 хувь нь “хэрэгжүүлэх механизм нь байхгүй”, 39.3 хувь нь “хуулийг сайн ойлгоогүй”, 39 хувь нь “ажлын ачааллаас болсон”, 27 хувь нь “мэдлэг сул байснаас”, 27 хувь нь “хуулийг хэрэгжүүлэх талаар тодорхой удирдамж байхгүй байгаагаас” гэж үзсэн байна.

Энэхүү сэдвийн хүрээнд сонирхолтой, халуун яриа, ярилцлага, асуулт хариулт өрнөлөө. Оролцогч-өмгөөлөгчдийн зүгээс цагдаа, прокурор, шүүгчдийн дунд байгаа хуучин менталитет нь энэхүү шинэ хуулийн өөрчлөлтүүдийг хэрэглэх, хүний эрхийг хамгаалахад саад болж байна гэж шүүмжлэв. Практикт гардаг алдаанууд, өмнөх хуулийн үед байсан зүйл бол мэдлэг, мэдээлэл, боловсрол, сэтгэлгээний

хоцрогдлын асуудал байсан. Мөн хуулийн салбаруудын салбар дундын уялдаа холбоо сул байгаагаас болдог гэж ихэнх оролцогчид үзэж байна.

Хуучин хуулийн үед өмгөөлөгчдийн оролцоо маш сул, хязгаарлагдмал байсан. Одоо ч энэ байдал үргэлжилж, өмгөөлөгчид эрүүгийн хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааны үеэр үйлчлүүлэгчдийнхээ хүний эрхийг хамгаалах оролцоо, эрх мэдэл хязгаарлагдмал хэвээр байгааг оролцогчдын зүгээс илэрхийллээ. Тиймээс аливаа хуулийн шинэчлэл, өөрчлөлтийн үйл явцад тэдний оролцоог сайн хангаж өгөх хэрэгтэй байгаа талаар бас ярилаа. Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г. Баясгалан энэ хуулийн өөрчлөлтүүдийг дахин хянаж үзэх байнгын ажиллагаатай ажлын хэсэг тус яаман дээр байгуулагдсан байгааг дурдлаа.



Д. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ГУРАВ “ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛЬ БА ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО

Д.1. Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах болон шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дахь олон улсын хүний эрхийн зарчим



Их Британи, Умарт Ирландын Вант улсын эрүүгийн эрх зүйн шинжээч, прокурорын зөвлөх ноён Фрэнсис Дэвид энэ сэдвээр илтгэл хэлэлцүүлээ. Эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хэрэгждэг хүний эрхийн чухал зарчмуудыг тэрээр дурдлаа.

Прокурор хүн шударга шүүхээр шүүлгэх эрх хичнээн үнэтэй болохыг мэддэг, шударга ёсыг тогтооход тэдний үүрэг ямар өндөр болохыг ухаарч мэдсэн, ойлгосон, бас үнэлдэг байх ёстой. Хохирогч төдийгүй гэмт хэрэгт сэжиглэгдэн, яллагдаж буй хүний хуулиар олгогдсон эрх хамгаалагдах, шүүхээр гэм буруутайг нь тогтоохоос өмнө хэнийг ч гэм буруутайд үл тооцох зарчим маш чухал гэдгийг ухамсарлах үүрэгтэй. Хэрэг хянах, мөрдөн шалгах үйл ажиллагаанд олон улсын хүний эрхийн бөгөөд ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах нь прокурор хүний эрхэм үүрэг гэдгийг ухамсарлах, сахих ёстой билээ.

Эрүүгийн хэргийг хянах, мөрдөн шалгах үйл ажиллагаанд цагдаа, мөрдөх албаны ажилтан, прокурор, өмгөөлөгчид мэргэжлийн бөгөөд шударга хандахад анхаарах ёстой. Тиймээс нэр хүндтэй олон улсын болон хүмүүнлэгийн

байгууллагууд /НҮБ, ОУ-ын Улаан загалмай нийгэмлэг, ОУ-ын Прокурорын холбоо/ эрүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагаа, шүүх таслах эрх мэдлийн үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгч, хүний эрхийг хангах, хууль дээдлэх ёсыг сахин биелүүлэх процесст мөрдлөг болгох дүрэм, журам, удирдамжуудыг баталж өгсөн.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал /ХЭТТ/ шударга шүүхээр шүүлгэх эрхийг хэрэгжүүлэх үндсэн зармыг тусгаж өгсөн байдаг. Энэхүү тунхаглалын нэгдүгээр зүйл “Хүн бүр эрх чөлөөтэй төрсөн бөгөөд өөрийн эрхэм чанар, хүний эрхтэй төрдөг” гэж эхэлдэг. Хүний эрхэм чанар хэмээх энэ чухал үнэт зүйл нь хүний үндсэн эрхийг хамгаалах, хүндэтгэхийн суурь нь болдог юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд “хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, аюулгүй байдалд амьдрах эрхтэй”, 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй” /энэ эрх 1987 оны Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор улам баталгаажсан/, 6 дугаар зүйл “Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй”, 9 дүгээр зүйл “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй”, 11 дүгээр зүйл “Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй” гэж заасан байдаг. Эдгээр зүйл заалтууд нь шударгаар хэргээ шийдвэрлүүлэх эрхийн баталгаа, үндэслэл болдог юм.

Цагдаа, прокурор хүнийг баривчилж, хорьж эхэлсэн цагаас хүний эрхийн хязгаарлалт үүсдэг тул хүний эрхийн асуудлууд эндээс эхлэн үүсэх магадлалтай. Тиймээс “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй” /7 дугаар зүйл/, “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” /8 дугаар зүйл/, “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй” /9 дүгээр зүйл/, “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй” /10 дугаар зүйл/ - эдгээр эрхийн хэрэгжилтэнд хяналт тавих, зөрчигдөхгүй байх баталгааг хангах нь прокурорын эрхэм үүрэг болдог.

Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, саатуулагдаж, хоригдсон этгээд өмгөөлүүлэх эрхээр хангагдах эрхтэй бөгөөд энэ эрхийг нь мэдүүлсэн байх ёстой. Хэрвээ тухайн хүн өмгөөлөгч хөлслөх санхүүгийн боломжгүй бол түүнийг хүсвэл төрөөс түүнийг өмгөөлөөгчөөр хангах арга хэмжээг зохион байгуулж өгнө.

Хабеас корпус-ыг хэрэгжүүлэх гэдэг нь сэжигтнээр цагдан хорих арга хэмжээ нь хуулийн дагуу үйлдэгдэх ёстой гэсэн үг юм. Ямар хэрэгт сэжиглэгдэж байгааг нь сэжигтэн, түүний өмгөөлөгчид бичгээр гаргаж өгч танилцуулна. Чухам ямар зүйлд

буруутган, сэжиглэн шалгаж байгааг тодорхой ойлгуулах нь чухал юм. Тэднийг холбогдолтой мэдээлэл, материалтай танилцах эрхээр хангах ёстой.

Сэжигтэн, яллагдагч бие даан өөрийнхөө буруугүйг нотлох мөрдлөг явуулж чадахгүй тул төр бүх талын нотлох баримтыг цуглуулах, мөрдөн шалгах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд зохион байгуулахад анхаарна. Бүх материалууд, түүнчлэн сэжигтэн, яллагдагчид ашигтай материалыг ч өмгөөлөгч талд гаргаж өгөх үүрэгтэй. Мөрдөн шалгах үйл ажиллагаа мэргэжлийн түвшинд зохион байгуулагдах ёстой. Прокурор, мөрдөгч, шүүгчид бүгдэд ашиг, сонирхлын зөрчил байж болохгүй. Тэгвэл, шударга ёсонд ан цав үүсч мэднэ.

Цагдан хорих үйл ажиллагаа хүний эрх чөлөөг хязгаарладаг тул энэ арга хэмжээг авч хэрэгжүүлэх нухацтай шалтгаан байх ёстой бөгөөд шүүх үүнийг маш сайн хянах ёстой. Шардлагагүй гэж үзвэл шүүхээс цагдан хорих арга хэмжээг хэрэглэхгүй байх шийдвэр гаргах, цуцлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Хууль болон бусад хуулийн чухал материалууд иргэдэд болон хууль, эрх зүйн салбарт ажиллаж буй хүмүүст нээлттэй байх нь чухал.

Шударга ёсыг хэрэгжүүлнэ гэдэг нь эрх зүйн процесс, түүнийг хүргэх үйл ажиллагаа нь хууль бус болон тохиолдлын шинжтэй байж болохгүйг хэлж буй юм. Шийдвэр гаргах үйл ажиллагаа хуулийн дагуу байх бөгөөд тодорхой бус, ойлгомжгүй байж болохгүй. Үгүй бол шийдвэрийг биелүүлэхэд асуудал үүснэ. Шударга ёсны системд эргэлзэх, ялгаварлан гадуурхалт, авилга байгаа гэж сэжиглэхэд хүргэнэ. Шударга ёсны системийг хэрэгжүүлэх бүх хэм хэмжээ, дүрэм журам, стандарт хүмүүст нээлттэй байх хэрэгтэй. Тэдгээрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд мэргэжлийн ёс зүйн алдаа төдийгүй эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдэл байж болно. Хууль зөрчиж, иргэдийн эрхийг зөрчсөн үйлдэл хийсэн, буруутай мөрдөн байцаагч, прокурортой иргэд хариуцлага тооцож, хохирлоо нөхөн төлүүлэх ёстой. Ингэснээр ирээдүйд ийм алдаа, зөрчил гарахаас, хүний эрх зөрчигдөхөөс хамгаалах боломж бүрдэх юм.

Д.2. Гэрч, хохирогчийг хамгаалах нь олон улсын хүний эрхийн чухал зарчим болох нь



Европын Холбооноос Монгол улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг дэмжих төслийн үндэсний зөвлөх, Тахарын албаны Гэрч, хохирогчийг хамгаалах газрын дарга асан М. Ичинноров энэхүү илтгэлийг хэлэлцүүлээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “ төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг,

нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй” гэж заасан. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад гишүүн улс бүр уг пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангахыг үүрэг болгосон. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 40\34 дугаар тогтоолоор 1985 онд “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”-ыг улсуудад уриалсан. Эдгээр нь гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоо, механизмаа бүрдүүлэх ёстой үндэслэл болж буй эрх зүйн баримт гол баримт бичгүүд юм.

Гэрч, хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр нөлөөлөх явдал эрүүгийн эрх зүйн практикт, амьдрал дээр гарсаар байгаа. Үүний үр дагавар нь нөлөөнд орж мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох оролдлого хийх, амиа хорлох зэрэг үйлдэл болж буйг 2010 оны Хохирогчийн эрхийн судалгааны төв болон НҮБ-ын хамтарсан “Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал” судалгааны тайланд дурджээ. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй этгээдүүд гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, бааз суурь байхгүй гэсэн үндэслэлээр гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг хийдэггүй байсан нь судалгаагаар тогтоогдсон.

Эрүүгийн нэг хэрэгт дунджаар нэг хохирогч, гурван гэрч байдаг гэж үзвэл жилд эрүүгийн хэрэгт дунджаар 5432 хохирогч, 16296 гэрч байдаг бөгөөд эдгээрээс 1199 хохирогч, 3597 гэрчийн аюулгүй байдал ноцтой байдалд ордог гэсэн гэсэн тооцооллыг судалгааны байгууллагууд Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийг батлуулах, Тахарын албыг байгуулах үндэслэл болгон гаргаж ирж байсан.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах 5 байгууллагыг нэрлэсэн /Цагдаа, Мөрдөх байгууллага, Тагнуулын байгууллага, АТГ, Тахар/. Эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бий болгох алхам огт хийгдээгүй орхигдсон. Тахарын албаны Гэрч, хохирогчийг хамгаалах газрын дэргэд аюулгүй байдлын хамгаалалтын тусгай хэлтэс байгуулж, хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах, эрүүл мэнд, хууль эрх зүй, сэтгэл зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлсэн. Харамсалтай нь энэ байгууллагыг 2016 онд татан буулгасан билээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн талаарх сургалтыг хууль, хяналтын байгууллагын ажилтнууд, өмгөөлөгчид, иргэдийн дунд зохион байгуулаагүй нь харамсалтай. Хуулийн дагуу 9 төрлийн хамгаалалтын арга хэрэгсэл /урьдчилан сануулах, тодорхой үйлдлийг хязгаарлах, биечилсэн хамгаалалт, хамгаалах хэрэгслээр хангах, аюулгүй газар байрлуулах, нүүлгэн шилжүүлэх, хувийн мэдэлэл, гадаад төрхийг өөрчлөх/ байгаа. Аюулгүй газар түр байрлуулах үйл ажиллагааг цэрэг, цагдаагийн хамгаалалт бүхий бүсэд, ТББ-ын байгуулсан хамгаалах байранд болон орон нутгийн засаг захиргаанаас байгуулсан хамгаалах байранд байрлуулах үйл ажиллагаануудыг тусгай журмаар зохицуулж болно.

Анхаарах чухал асуудлууд бол гэрч, хохирогч мэдүүлэг өгч эхэлсэн цагаас аюулгүй байдал нь эрсдэлд орох боломжтой. Гэтэл тэднийг цагдаагийн шатанд хамгаалалтанд авах арга хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, төсөв зардал байхгүй байгааг анхаарах шаардлагатай байна. Цагдаа гэрч, хохирогчоос мэдүүлэг авахдаа тусад нь дуудаж авах, шаардлагатай гэж үзвэл байгаа газар нь очиж авах, сэтгэл зүйн айдас түгшүүрийн байдлыг нь харгалзан үзэж мэдрэмжтэй хандах нь маш чухал байна. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагуудыг хүн хүч, техник хэрэгслэл, материаллаг баазаар хангах, тэдний гэрч, хохирогчтой харьцах сэтгэл зүйн талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, зөв хандлага төлөвшүүлэх нь чухал.

Хууль сахиулах байгууллагын алба хаагчид, тэр тусмаа анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа цагдаагийн ажилтнуудыг өөрсдийг нь гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийг төрийн нэрийн өмнөөс өмгөөлөн хамгаалагчид гэдэг итгэл үнэмшил, сэтгэлгээг суулгах. Гэр бүлийн хүчирхийлэл, хүчин болон бусад бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчидтой ажилладаг тусгай сэтгэл зүй, чадвар ,

сэтгэлгээ бүхий тусгай тасгуудыг цагдаа, мөрдөх алба, прокурорын анхан шатны хэсэг, нэгжүүд дээр байгуулах. Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжих боломжтой нөхцөлтэйгээр буюу төсөвтэй нь батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Д.3. Эрүүгийн эрх зүйн тогтолцоо: Эрүүдэн шүүхийн эсрэг болон бусад хүний эрхийн конвенцийн хэрэгжилт



Монголын Эмнести Интернэшнлийн УЗ-ийн дарга Б.Болорсайхан “Эрүүгийн эрх зүйн тогтолцоо: Эрүүдэн шүүхийн эсрэг болон бусад хүний эрхийн конвенцийн хэрэгжилт”сэдвээр илтгэл хэлэлцүүлээ.

2008 онд Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хүний эрхийн үндэсний комисс хамтран Монгол улсын хууль

тогтоомжууд олон улсын гэрээ хэлэлцээр, конвенцид хэрхэн нийцэж буй талаар судалгаа хийхэд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн уухай олон улсын пакт – 3 хувийн үнэлгээ /1- хангалтгүй, 5-маш хангалттай/, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт – 3.7 хувийн үнэлгээ, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц – 3.2 хувь, Ялгаварлан гадуурхалтын эсрэг НҮБ-ын конвенци- 4 хувь, Хүүхдийн эрхийн конвенци- 3 хувийн үнэлгээ авчээ.

Олон улсын хүний эрхийн стандартыг хэрэгжүүлэхэд хийсэн маш том ухралт бол гэрч, хохирогчийг хамгаалах тусгай үүрэг бүхий байгуулагдсан Тахарын албыг татан буулгасан явдал гэдгийг дурдлаа. Эрх баригчид энэхүү газрыг ажиллуулах санхүүгийн эх үүсвэр дутмаг байдлаас татан буулгасан гэж тайлбарлаж буй. Үүнтэй санал нийлэх боломжгүй юм. Учир нь зөв сэтгэлгээ, хандлага байсан цагт санхүүгийн эх үүсвэрийн асуудлыг үргэлж шийдвэрлэх боломжтой байдаг. Энэ байгууллагыг дахин байгуулах хэрэгтэй. Мөн хууль, хяналтын байгууллагын ажилтнуудын хууль бус үйл ажиллагааг мөрдөн шалгаж, хууль бус үйлдэлийг таслан зогсоох, хүний эрхийг зөрчигдөхөөс хамгаалах тусгай мөрдөн шалгах тасгийг УЕПГ-ын дэргэд байгуулах ёстой.

Хууль, хяналтын байгууллагын ажилтнуудын дунд гүн бат тогтсон яллах сэтгэлгээг халахгүйгээр, шударга ёсонд суурилсан сэтгэлгээг бий болгохгүйгээр эрүүгийн эрх зүйн тогтолцоонд шинэчлэл явагдахгүй бөгөөд хүний эрх бүрэн хамгаалагдахгүй билээ. Шүүх засаглалын үйл ажиллагаанд олон улсын хүний

эрхийн хэм хэмжээг хэрэглэж сурахгүйгээр Монгол улсад хүний эрх хэрэгжих, хангагдах боломжгүй юм. Шүүгч олон улсын гэрээг шүүхийн шийдвэр гаргахдаа ашиглах ёстой. Гэтэл, тэдгээр олон улсын гэрээ, конвенци нь зөвхөн төрийн мэдээлэл сонинд хэвлэгдсэний дараа л шүүхийн шийдвэрт хэрэглэх боломжтой. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколын дагуу үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бүрдүүлсэн байх ёстой. Энэ нь байхгүйгээс эрүүдэн шүүлтийн хохирогчид хохиролоо нөхөн төлүүлэх, эрхээ сэргээлгэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.



Е. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ДӨРӨВ “ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО БА ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ НЬ”

Е.1. Жендерт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа



Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэсийн Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн дарга Д. Будзаан “Жендерт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа” сэдвээр илтгэл тавьлаа. Цагдаагийн

судалгаа, мэдээллээр өнгөрсөн оны байдлаар нийт 455.000 дуудлага хүлээн авсанаас 31.000 нь гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл дэх амар тайван байдал алдуулсан талаарх дуудлага байсан. 31.000 дуудлагын 5807 –д нь хэргийн аюулгүйн зэргийн үнэлгээ хийгдсэн байдаг.

Цагдаад хандаж ирсэн иргэдэд зориулан тусламжийн мэдээллийн хуудас өгдөг бөгөөд энэ хуудсанд хууль тогтоомж, тэдний эрхийн талаарх мэдээлэлийг өгсөн байдаг юм. Иргэдийн эрхийн тухай боловсролыг дээшлүүлэх ажлыг төр засгийн зүгээс дорвитой зохион байгуулах хэрэгтэй, үүнийг боловсролын тогтолцоонд суулгаж өгөх хэрэгтэй байна. Хүүхдэд багаас нь хүчирхийллийн бус соёл, зан чанар төлөвшүүлэх, охид эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх механизмыг сургуулийн тогтолцоонд бодлогоор суулгаж өгөх шаардлагатай байгааг амьдрал харуулж байна.

Түүнчлэн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн талаар сургалт цагдаагийн байгууллагын ажилтнуудад нэн шаардлагатай байна. Мөн энэ талаарх сургалтыг иргэдийн дунд ч зохион байгуулж, өөрсдийг нь мэдлэгээр хангах хэрэгтэй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэлийн үр дүнд болон иргэдийн дунд энэ талаарх мэдээлэл тодорхой хэмжээнд сайжирсаны үр дүнд цагдаагийн байгууллагын хувьд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд ахиц, дэвшил гарч байна. Цагдаад хандах хохирогчдын тоо нэмэгдэж байгаа нь тэдний аюулгүй байдлыг хамгаалах механизмыг бүрдүүлэх, тэдэнд үзүүлэх үйлчилгээг

сайжруулах хүн хүчний нөөц, чадавх, эдийн засгийн чаамжийг дээшлүүлэх асуудал тулгарч байгаа юм.

Иргэний нийгэм, боловсролын байгууллагуудын оролцоо, дэмжлэгтэйгээр иргэдийнхээ боловсрол, соёлд өөрчлөлт хийх замаар гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг төр хэрэгжүүлэх шаардлагатай байгааг дурдах нь зүйтэй.

МонФемНет үндэсний сүлжээний зохицуулагч Д. Энхжаргал “Богино хугацаанд мэдэгдэхүйц өөрлөлтүүд бий болж байна. Жишээлбэл, хүчирхийлэгчийнхээ гарт амь үрэгдэгдэгсдийн тоо буурч байна. Эрүүгийн хуулинд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлийг гэмт хэрэгт тооцож өгсөн нь маш чухал дэвшил юм” хэмээн хэллээ.

Е.2. Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа



Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны төв- ТББ-ын захирал Б. Жавзанхүү илтгэлдээ насанд хүрээгүй хохирогч, гэрч нарын хувьд учирч буй хүндрэл, бэрхшээлүүдийн талаар ярьлаа. Цагдаа, хууль хяналтын байгууллагын зүгээс хохирогч, гэрч хүүхдээс хохирол, нотолгоо шаардах, гомдол, нэхэмжлэлээ буцаах,

хэрэгсэхгүй болгох, эвлэрүүлэх оролдлого хийх, гэр бүлээс тусгаарлах нөхцөлд оруулах зэрэг байдлууд практикт элбэг байдаг.

Эрүүгийн хэргийг хянан шалгах үйл ажиллагаанд хохирогч хамгааллын сэтгэлгээ хандлага сул, хүүхдийн эрхийн мэргэжилтэн, шинжээчдийг оролцуулдаггүйгээс хүүхдийн эрх ашиг зөрчигддөг. Хүүхдийн хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах эрхийг зөрчих, тэр бүү хэл, бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч хүүхдийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр цацах зэрэг зөрчлүүд гарсаар байна.

Гэмт хэрэгт оролцсон, ял шийтгэл хүлээсэн хүүхдийн асуудалд хандах хандлага сул хэвээр байсаар байна. Тэднийг буруутгах, хүүхэд залууст буруу хандах байдал байсаар байгаа нь тэдгээр хүүхдүүдийн дунд хийсэн судалгаагаар батлагдаж байна. Тэдгээр хүүхдийн 80% нь шүүх хурал болтол сэтгэлийн

дарамттай, хар дарж зүүдэлдэг, 70% нь байцаалтаас хойш амиа хорлох бодол тээж байсан, 15% нь ийм оролдлого хийж байсан, 10% нь урьдчилан хорих нөхцөлд буюу “Ганц худаг”-т байхдаа шоконд орсон байдаг. Ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, нийтэд тустай ажил хийлгэх; зорчих эрхийг хязгаарлах; сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих зэрэг шийтгэлийн арга хэмжээг нэвтрүүлэх шаардлагатай.

Гэмт хэргийн хохирол хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, нийтэд тустай тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь, эсхүл зөвшөөрснөөр нь даалгаж болно

Үр дүнг үл хайхрах, цагдаа, хүүхдийн байгууллагын ажилтны хамтрах эрмэлзэл сул, засаг дарга хуулиа үл биелүүлэх, эцэг эх, хүүхэд хандах хүнгүй зэрэг асуудлууд байсаар байгааг дурдах хэрэгтэй. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж буй хувь хүмүүс, байгууллагыг төрөөс урамшуулан дэмжих ажлыг зохион байгуулах. Монгол улс хүүхэд хамгаалалтын системээ олон улсын стандартанд хүргэж, хамгаалалтын үндэсний системээ бэхжүүлэх шаардлагатай байна. Салбар хоорондын уялдаа холбоо сайн байх ёстой. Гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй байгаа билээ. Эмзэг бүлгийн гэр бүлүүдэд ядуурлаас чөлөөлөгдөх удирдамж, дэмжлэг хэрэгтэй байна. Гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар цагдаагийн байгууллагын ажилтнуудыг сургах, тэдний чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ байгааг дурдлаа.

Хүүхэд хамгааллын шинэчлэл-хандлагыг өөрчлөх, үнэт зүйлсийг ухамсарлуулах, хууль тогтоомжийг шинэчлэх, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай (хохирогчийг хамгаалах), Зөрчлийн хууль тогтоомж: (хүүхдийн эрхийн улсын байцаагч), Эрүүгийн хуультай уялдуулж хэрэглэх, бодлого, хэрэгжилтийн уялдааг хангаж, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэх хэрэгтэй байгааг илтгэлдээ онцоллоо.

Е.3. Насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудал: Олон улсын стандарт



“Насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудал ба олон улсын стандарт” сэдвээр Голланд улсаас ирсэн олон улсын хүний эрхийн шинжээч Мартже Бергер өөрийн олон улсын туршлага, мэдлэгтээ тулгуурлан энэхүү илтгэлийн толилууллаа.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенци /ХЭТК/ хүүхэд бол тусгай эрх зүйн

статустай гэдгийг тодорхойлж өгсөн. 1990 он гэхэд, Монгол улс энэ конвенцийг соёрхон баталсан анхны орнуудын нэг байсан. Хэдий тийм ч хүүхдийн эрх зөрчигдсөн олон асуудал Монгол улсад байна. Хууль эрх зүйн системтэй нүүр тулсан хүүхдүүдтэй том хүний адил харьцдаг, цагдаагийн хүчирхийлэлийн золиос болох тохиолдол байсаар байгаа. Хүүхдүүдэд хорихоос өөр төрлийн, хүмүүжлийн арга хэмжээ авах тогтолцоо дулимаг байна. Эцэг, эх нь шоронд хоригдож буй хүүхдүүдийн байдал тун хүнд, эмзэг байдалд байгаа. Хүүхдүүд хурдан морьны уралдаанд хөдөлмөрийн мөлжлөгийн хохирогч болох, хүний наймаа, хүчирхийлэлийн золиос болох тохиолдол бас бий.

Монгол улсад насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх системийг шинэчилж, цогцоор бүрдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд Монгол улс ХЭТК-ийн 37, 40 дүгээр зүйлүүдэд заасан хэм хэмжээг бий болгох. Ингэхдээ ХЭТК-ийн ерөнхий зарчмын 2,3,6 болон 12 дугаар зүйлийг удирдлага болгох ёстой. ХЭТК-ийн 37, 40 дүгээр зүйлүүдийг хэрэгжүүлэх тусгайлсан удирдамж дараах баримт бичгүүдэд тусгагдсан болно:

- Насанд хүрээгүй хүүхдийг хэрэг эрхлэх асуудлаарх Бээжингийн дүрэм -/ Beijing Rules/
- Эрх чөлөөгөө хасуулсан насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах Гаванагийн дүрэм - /Havana Rules/
- Ерөнхий зөвлөмж 10- Насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудал ба хүүхдийн эрх /2007/

Монгол Улс ЕХ-ны гишүүн орнуудын энэ асуудлаарх сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх хэрэгтэй. Үүний дотор, Европын парламентаас баталсан ЕХ-ны

2016/800 удирдамж нь насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийн эрхийг хамгаалах асуудалд удирдамж болгодог чухал баримт бичиг бий. Энэ нь ЕХ-ны улсуудын мөрдлөг болгох ёстой зармчуудыг тусгасан байгаа. Мөн 2010 онд Европын зөвлөлийн сайдуудын зөвлөлөөс баталсан ЕХ-ны “Хүүхдэд ээлтэй шударга ёсны системийг хэрэгжүүлэх” удирдамж байдаг. (<https://rm.coe.int/168045f5a9>).

Монгол улс бусад улс орнуудын сайн туршлагаас суралцах хэрэгтэй. Үүний нэг нь хүүхдэд ээлтэй шударга ёсны институцийг амжилттай байгуулсан Испани улсын туршлага байна. Мөн Бельги, Умард Ирланд, Аргентин зэрэг улсууд бий. Эдгээр улсуудын сайн туршлага нь шийтгэх биш хүмүүжүүлэх системийг хөгжүүлэх эрх зүйн үндсийг сайтар бүрдүүлсэн байна.

ХЭТК болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн зөвлөмжид тусгасан даалгаваруудыг биелүүлэх үүрэг Монгол улсын өмнө бий. Тиймээс, хүүхдэд ээлтэй эрх зүйн системийг бий болгох талаар дорвитой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх, энэ үйлсэд хүүхэд, залуусын оролцоог хангах учиртай. Монгол улс насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудлаар тусгай хууль бий болгох, энэ асуудлыг хариуцсан тусгай институц бий болгох, процессыг боловсронгуй болгох хэрэгтэй. Энэхүү системийг бий болгохдоо, нийгмийн цөөнх болох казак, цаатан хүүхдүүдийн эрхийг хамгаалах асуудлыг орхигдуулж болохгүй.

Ерөнхий зөвлөмжийн хүрээнд 2017 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн комиссын зүгээс дараах чиглэлийг өгсөн болно:

- Насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх хүүхдэд ээлтэй эрх зүйн тогтолцоог бий болгох
- Хүүхдийн асуудлаар мэргэшсэн шүүгчидтэй байх
- Өсвөр насны болон залуучуудад зориулсан хорих ангийн удирдамжтай байх /ХЭТК-ыг мөрдсөн/
- Хараат бус, үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээг бий болгох
- Тэнсэн харгалзах ял, тусгаарлах ялыг хэрэгжүүлэх, хорихоос өөр төрлийн хүмүүжүүлэх ялыг хэрэглэх, нийгэмшүүлэх, боловсруулах, амьдрах ур чадвар суулгах үйл ажиллагуудад хөрөнгө оруулалт хийх, дэмжлэг үзүүлэх
- Том хүмүүстэй хамт хорихыг цээрлэх, боловсрол,эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх нөхцөлөөр хангах зэрэг болно.

Мөн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн комисс 2016 оны 9 дүгээр сард гаргасан тайлан (CAT/C/MNG/2)-д ХЭТК-ийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу шүүгч, прокурор нарыг мэргэшүүлэх асуудал анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Мөн энэхүү зөвлөмжөөр Монгол улсыг хүүхдэд ээлтэй, хорихоос өөр төрлийн ялыг хэрэгжүүлэх тогтолцоог хангах, хорих газар хоригдож буй хүүхдүүдийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авахыг үүрэгжүүлсэн болно.

III. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль, шүүхийн өмнө тэгш байх эрх, хувь хүний халдашгүй байдлыг хамгаалах, шүүх эрх мэдлийн хараат бус байдал, шударга шүүхээр шүүлгэх эрх зэрэг хүний эрх баталгаажих, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нөхцөл шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулинд тусгалаа олсон гэж дүгнэж байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэхэд гарч буй хамгийн том саад бэрхшээл бол хуулийн өөрчлөлтийг нэг мөр ойлгох, хэрэглэх талаарх мэдлэг, сургалт дутмаг байгаагаас гадна сэтгэлгээний хоцрогдлын асуудал, мэргэжлийн ёс зүйн асуудал, шүүгч, прокурор, цагдаагийн ажилтны арга барилын хоцрогдол нөлөөлж буй гэдэгтэй оролцогчид санал нэгтэй байна.

Хүний эрхийн зөрчилд хөтөлдөг зөвхөн байцаалтанд суурилсан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг байсан практикаас татгалзах, эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд мөрдөн шалгах бусад арга барил, тактикуудыг нэвтрүүлж ажиллах нь шинэ хуулиар өгөгдөж буй бас нэгэн дэвшил юм. Эцэс төгсгөлгүй удаан хугацаагаар хэргийг мөрдөх хугацааг дахин дахин сунган, мөрдөн шалгадаг байсан нөхцөл байдалд цэг тавьж, шуурхай шийдэх, хугацааны хувьд хязгаарлалтуудыг бий болгож өгсөн нь бас нэгэн ахиц гэж үзэж байгаа юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн бас нэгэн чухал өөрчлөлт бол гүйцэтгэх ажиллагааны шугамаар олж авсан мэдээлэлийг зөвхөн прокурорын зөвшөөрөлтэйгөөр хийгдсэн тохиодолд шүүхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэх зохицуулалтыг хийсэн. Цаашид хэрэг хянах, мөрдөн шалгах, шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд олон улсын хүний эрхийн бөгөөд ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах нь чухал байна.

Оролцогчдын зүгээс Эрүүгийн шинэ хууль, ЭХШХТХ-ийг хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээлийн үндсэн шалтгаан нь эдгээр хуулийг нэг мөр ойлгох, хэрэглэх, тайлбарлах тал дээр хууль сахиулагч, хуульч мэргэжилтнүүдийг сайн сургах цаг хугацаа хомсхон, бэлтгэл муу байснаас болсон гэж үзэж байна. Иймээс ийм төрлийн сургалт, хурал, хэлэлцүүлгүүдийг хуульчдын дунд олноор зохион байгуулах, хуулийн өөрчлөлтийг олон нийтэд сурталчлан таниулах болон энэ чиглэлд ажиллах хүмүүсийн чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах шаардлатай байгаа гэдэгт санал нийлж байна.

Цагдан хорих үйл ажиллагаа хүний эрх чөлөөг хязгаарладаг тул энэ арга хэмжээг авч хэрэгжүүлэх нухацтай шалтгаан байх ёстой бөгөөд шүүх үүнийг маш сайн хянах ёстой. Шаардлагагүй гэж үзвэл шүүхээс цагдан хорих арга хэмжээг хэрэглэхгүй байх шийдвэр гаргах, цуцлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Сэжигтэн, яллагдагч бие даан өөрийнхөө буруугүйг нотлох мөрдлөг явуулж чадахгүй тул төр бүх талын нотлох баримтыг цуглуулах, мөрдөн шалгах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд зохион байгуулахад анхаарах хэрэгтэй гэдэгтэй санал нийлж байна. Прокурор, мөрдөгч, шүүгчид бүгдэд хамааралтайгаар ашиг, сонирхлын зөрчил байж болохгүй. Тэгвэл, шударга ёсонд ан цав үүсч мэднэ. Шударга ёсыг хэрэгжүүлнэ гэдэг нь эрх зүйн процесс, түүнийг хүргэх үйл ажиллагаа нь хууль бус болон тохиолдлын шинжтэй байж болохгүйг хэлж буй юм. Шийдвэр гаргах үйл ажиллагаа хуулийн дагуу байх бөгөөд тодорхой бус, ойлгомжгүй байж болохгүй.

Шударга ёсыг хэрэгжүүлэх бүх хэм хэмжээ, дүрэм журам, стандарт хүмүүст нээлттэй байх хэрэгтэй. Хууль болон бусад хуулийн чухал материалууд иргэдэд болон хууль, эрх зүйн салбарт ажиллаж буй хүмүүст нээлттэй байх нь чухал.

Монгол улсын Засгийн газар болон эрүүгийн эрх зүйн тогтолцооны оролцогч субъектуудын хувьд эрүүгийн эрх зүйн тогтоцооны шинэчлэлийг түргэтгэх зорилгоор НҮБ-ын хүний эрхийн гэрээний байгууллагуудын тайланг ашиглах хэрэгтэй гэж зөвлөж байна.

Монгол улсын Засгийн газар олон улсын хүний эрхийн хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжиндоо тусгах, хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа хурдтай ахиц гаргах шаардлагатай гэдгийг мөн зөвлөж байна.

Монгол улс цаазаар авах ялыг сэргээх нь олон нийтийг түгшээсэн хүнд гэмт хэргүүдийг таслан зогсоох шийдэл биш харин тийм гэмт хэрэг үйлдэгдэх нийгмийн учир шалтгааныг илрүүлэх, эмчлэх шаардлагатай бөгөөд цаазаар авах ялыг устгах олон улсын чиг хандлагаа барих, хүний амьд явах эрхийн асуудалд хүндэтгэлтэй хандах үүргээ сахин биелүүлэх шаардлагатай байгааг зөвлөж байна.

Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг нэг мөр, зөв тайлбарлах, хэрэглэх нь эрүүгийн процессын оролцогчдын зүгээс ямар нэг ялгаварлан гадуурхалт, авилга байгаа гэсэн хардалт дагуулахгүйгээр мэргэжлийн түвшинд ажиллах нэгэн баталгаа нь болж өгнө гэдгийг эрүүгийн эрх зүйн харилцаанл голлох үүрэгтэй оролцдог субъектуудэд зөвлөж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагуудыг хүн хүч, техник хэрэгслэл, материаллаг баазаар хангах, тэдний гэрч, хохирогчтой харьцах сэтгэл зүйн талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, зөв хандлага төлөвшүүлэх нь чухал байгааг зөвлөж байна.

Хууль сахиулах байгууллагын алба хаагчид, тэр тусмаа анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа цагдаагийн ажилтнуудыг өөрсдийг нь гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийг төрийн нэрийн өмнөөс өмгөөлөн хамгаалагчид гэдэг итгэл

үнэмшил, сэтгэлгээг суулгах. Гэр бүлийн хүчирхийлэл, хүчин болон бусад бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчидтой ажилладаг тусгай сэтгэл зүй, чадвар , сэтгэлгээ бүхий тусгай тасгуудыг цагдаа, мөрдөх алба, прокуторын анхан шатны хэсэг, нэгжүүд дээр байгуулахыг зөвлөж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжих боломжтой нөхцөлтэйгээр буюу төсөвтэй нь батлан хэрэгжүүлэх шаардлагатай байгааг Засгийн газарт зөвлөж байна.

Цагдаа, прокурорын дэргэд гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тусгай тасгуудыг бий болгох хэрэгтэй гэдгийг Засгийн газарт зөвлөж байна.

Иргэний нийгэм, боловсролын байгууллагуудын оролцоо, дэмжлэгтэйгээр иргэдийнхээ боловсрол, соёлд өөрчлөлт хийх замаар гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг төр хэрэгжүүлэх шаардлагатай байгааг зөвлөж байна.

Насанд хүрээгүй хүүхдэд тэнсэн харгалзах ял, тусгаарлах ялыг хэрэгжүүлэх, хорихоос өөр төрлийн хүмүүжүүлэх ялыг хэрэглэх, нийгэмшүүлэх, боловсруулах, амьдрах ур чадвар суулгах үйл ажиллагауудад хөрөнгө оруулалт хийх, дэмжлэг үзүүлэх хэрэгтэйг зөвлөж байна.

Хүүхдэд ээлтэй эрх зүйн системийг бий болгох талаар дорвитой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх, насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудлаар тусгай хууль бий болгох, энэ асуудлыг хариуцсан тусгай институт бий болгох, процессыг боловсронгуй болгох хэрэгтэй байгааг зөвлөж байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн конвенц болон ХЭТК-ийн зөвлөмжид тусгасан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх үйл явцыг түргэтгэх шаардлагатай байгааг зөвлөж байна.

IV. ЧИГЛҮҮЛЭГЧ, ИЛТГЭГЧИДИЙН НЭРС

Нээлтийн үйл ажиллагаа:

- Гадаад Харилцааны Яамны төрийн нарийн бичгийн дарга Д. Даваасүрэн
- Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан
- Европын Холбооны Монгол улс дахь Төлөөлөгчийн Газрын хэргийг түр хамаарагч Марко Ферри

Нэгдүгээр хэсэг: “ЭРҮҮГИЙН ШИНЭ ХУУЛЬ: ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ”

Чиглүүлэгч: Монгол Улсын Ерөнхий Прокурорын Орлогч, Төрийн Хууль Цаазын Шадар Зөвлөх Г. Эрдэнэбат

Илтгэгчид:

- Улсын Ерөнхий Прокурорын Газар, Сургалт Судалгааны Төвийн судлаач, хяналтын Прокурор Г. Оюунболд
Илтгэлийн сэдэв: “Гэмт хэргийн зүйлчлэл болон Эрүүгийн хуультай холбогдон өөрчлөгдөн батлагдсан бусад хууль тогтоомжийн шинэчлэлийн асуудал”
- Монгол Улсын Их Сургууль, Хууль Зүйн Сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D) Д.Баярсайхан
Илтгэлийн сэдэв: “Ялын бодлого ба хүний эрх: Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн асуудал”

Хоёрдугаар хэсэг: “ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ БА ХҮНИЙ ЭРХ”

Чиглүүлэгч: Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны Төрийн нарийн бичгийн Г. Баясгалан

Илтгэгчид:

- Монгол Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл дүн шинжилгээний төвийн дарга Б.Бат-Орших
Илтгэлийн сэдэв: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэл, өөрчлөлтийн асуудал”

- Санхүүгийн Зохицуулах Хорооны Төрийн Захиргаа, Удирдлагын газрын дарга Б.Батзориг
Илтгэлийн сэдэв: “Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаан дахь хүний эрхийн хэрэгжилт, сорилт, бэрхшээлүүд ”

Гуравдугаар хэсэг: “ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛЬ БА ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО”

Чиглүүлэгч: Хүний Эрхийн Үндэсний Комиссын дарга Ж. Бямбадорж

Илтгэгчид:

- Олон улсын хүний эрхийн эксперт Франсис Дэвид /Англи улс/
Илтгэлийн сэдэв: “Эрүүгийн хэргийн мөрдөн шалгах болон шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дахь олон улсын хүний эрхийн зарчим”
- Европын Холбооноос Монгол улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг дэмжих төслийн үндэсний зөвлөх М. Ичинноров
Илтгэлийн сэдэв: “Гэрч, хохирогчийг хамгаалах нь олон улсын хүний эрхийн чухал зарчим болох нь”
- Монголын Эмнести Интернэйшнл ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга Б. Болорсайхан
Илтгэлийн сэдэв: “Эрүүгийн эрх зүйн тогтолцоо: Эрүүдэн шүүхийн эсрэг болон бусад хүний эрхийн конвенцийн хэрэгжилт”

Дөрөвдүгээр хэсэг: “ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО БА ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ НЬ”

Чиглүүлэгч: МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээний Ерөнхий Зохицуулагч Д.Энхжаргал

Илтгэгчид:

- Цагдаагийн Ерөнхий Газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн Хүүхдийн эрхийн гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн дарга Д.Будзаан
Илтгэлийн сэдэв: “Жендерт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа”
- Хүүхдийн Эрхийн Сургалт, Судалгааны хүрээлэнгийн захирал Б. Жавзанхүү
Илтгэлийн сэдэв: “Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа”
- Олон улсын хүний эрхийн эксперт Мартже Бергер (Голланд)

Илтгэлийн сэдэв: “Насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудал: Олон улсын стандарт”

Хаалтын үйл ажиллагаа:

- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр
- Европын Холбооны Монгол улс дахь Төлөөлөгчийн Газрын хэргийг түр хамаарагч Марко Ферри
- Европын Холбооноос Монгол улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг дэмжих төслийн олон улсын зөвлөх, багийн ахлагч Хенк Хулсоф

ХАВСРАЛТ # 1 ОРОЛЦОГЧДЫН НЭРС

#	Нэр	Байгууллага
1.	Д. Даваасүрэн	Гадаад Харилцааны Яамны төрийн нарийн бичгийн дарга
2.	Б.Энхбаяр	Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
3.	Марко Ферри	Европын Холбооны Монгол улс дахь Төлөөлөгчийн Газрын хэргийг түр хамаарагч
4.	Хенк Хулсоф	Европын Холбооноос Монгол улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг дэмжих төслийн олон улсын зөвлөх, багийн ахлагч
5.	Г. Эрдэнэбат	Монгол Улсын Ерөнхий Прокурорын Орлогч Төрийн Хууль Цаазын Шадар Зөвлөх
6.	Г. Оюунболд	Улсын Ерөнхий Прокурорын Газар, Сургалт Судалгааны Төвийн судлаач, хяналтын Прокурор
7.	Д.Баярсайхан	Монгол Улсын Их Сургууль, Хууль Зүйн Сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D) Д.Баярсайхан
8.	Б.Бат-Орших	Монгол Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвийн дарга
9.	Б. Батзориг	Санхүүгийн Зохицуулах Хорооны Төрийн Захиргаа, Удирдлагын газрын дарга
10.	Франсис Дэвид	Олон улсын хүний эрхийн эксперт /Англи улс/
11.	Ж. Бямбадорж	Хүний Эрхийн Үндэсний Комиссын дарга
12.	М. Ичинноров	Европын Холбооноос Монгол улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг дэмжих төслийн үндэсний зөвлөх
13.	Б. Болорсайхан	Монголын Эмнести Интернэйшнл ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга
14.	Д.Энхжаргал	МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээний Ерөнхий Зохицуулагч
15.	Г.Арсланхуяг	Ц агдаагийн Ерөнхий Газрын Гэмт хэргээс урьдчилан

		сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа
16.	Б. Жавзанхүү	Хүүхдийн Эрхийн Сургалт, Судалгааны хүрээлэнгийн захирал
17.	Мартже Бергер	Олон улсын хүний эрхийн эксперт
18.	П.Сайнзориг	ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга
19.	Л.Мөнхцэцэг	ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
20.	Д.Саруул	ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
21.	Б.Гантуяа	ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
22.	Я.Жавхлан	ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн
23.	Ч.Нарантуяа	ХЗДХЯ-ны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн
24.	Д.Гантуяа	ХЗДХЯ-ны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн
25.	Г.Сарнай	ХЗДХЯ-ны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн
26.	О.Алтангэрэл	УЕПГ-ын Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга
27.	М.Оюундэлгэр	УЕПГ-ын Хяналт шалгалт, Дотоод Аюулгүй байдлын хэлтсийн дарга
28.	М.Гантулга	УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн захирал
29.	У.Эрдэнэтуяа	УЕПГ-ын Эрх зүйн туслалцаа, Гадаад харилцааны хэлтсийн хяналтын прокурор
30.	Ж.Ариунаа	ХУД-ийн Прокурорын Газрын Ерөнхий Прокурор
31.	Ц.Батболд	БЗД-ийн Прокурорын Газрын Ерөнхий Прокурор
32.	Д.Булганцэцэг	ЧД-ийн Прокурорын Газрын Ерөнхий Прокурор

33.	Г.Бат-Очир	СБД-ийн Прокурорын Газрын Ерөнхий Прокурор
34.	Н.Энхтуяа	БГД-ийн Прокурорын Газрын Ерөнхий Прокурор
35.	Д.Отгонбаяр	СХД -ийн Прокурорын Газрын Ерөнхий Прокурор
36.	Д.Баярмагнай	Нийслэлийн Прокурорын Газрын Ерөнхий Прокурор
37.	Ү.Содномцог	Тээврийн Прокурорын Газрын Ерөнхий Прокурор
38.	Э. Сэргэлэн	ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч
39.	Д. Мөнхзул	ЦЕГ-ийн Эрүүгийн цагдаагийн албаны албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мөрдөгч, цагдаагийн ахмад
40.	Х. Мандах	ЦЕГ-ийн Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа
41.	Л. Эрхзаяа	ЦЕГ-ийн Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн ахлах мөрдөгч цагдаагийн ахмад
42.	Б. Батзориг	ЦЕГ-ийн Урьдчилан сэргийлэх хэлтсийн Чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа
43.	Д. Будзаан	ЦЕГ-ийн Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн дарга, цагдаагийн ахмад
44.	Ү.Очирбуд	ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албаны ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа
45.	Д.Баярсүрэн	ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албаны ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч
46.	Н. Баясгаланбат	Нийслэлийн цагдаагийн газрын Мөрдөн шалгах газрын Хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн хурандаа
47.	Т. Чинбат	Нийслэлийн цагдаагийн газрын Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мөрдөгч, цагдаагийн ахмад
48.	Д.Сандаг	ШШГЕГ-ын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн,

		ахмад
49.	Л.Чойдонжамц	ШШГЕГ-ын Хуулийн хэлтсийн хэлтсийн мэргэжилтэн, ахлах дэслэгч
50.	З.Ариунбаяр	Хорих ял эдлүүлэх албаны Нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэслэгч
51.	Ц.Ганчимэг	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны Албадлагын арга хэмжээний хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч
52.	Ш.Байгалмаа	Шийдвэр гүйцэтгэх албаны Мэргэжлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч
53.	Ц.Гантулга	ШШҮХ-ийн дэд захирал, цагдаагийн хурандаа
54.	Г.Дагиймаа	ШШҮХ-ийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын дарга, Цагдаагийн хошууч
55.	Б.Энх-Амгалан	ШШҮХ-ийн Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа
56.	Г.Халиунаа	ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан
57.	М.Очирбат	ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан
58.	Д.Эрдэнэбаатар	Хууль сахиулахын их сургуулийн дэд захирал, цагдаагийн хурандаа
59.	Л.Бат-Очир	Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй криминологийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад
60.	Б.Хишигтогтох	Цагдаагийн сургуулийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хурандаа
61.	П.Эрдэнэбаатар	Цагдаагийн сургуулийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа
62.	Б.Мөнхзаяа	Ахисан шатны боловсролын сургуулийн Мэргэжлийн сургалтын профессоровын багийн ахлах багш, хошууч
63.	Т.Азжаргал	Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн

		онолын тэнхимийн багш, ахмад
64.	Т.Өсөхбаяр	Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах заалдах шатны шүүхийг шүүгч
65.	Л.Данзанноров	Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн, Өмгөөллийн "Монгол Өмгөөлөл" ХХН-ийн өмгөөлөгч
66.	К.Бауиржан	Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн Өмгөөллийн "Монгол Элч" ХХН-ийн өмгөөлөгч
67.	Д.Бурмаа	Монголын Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүн, ИЗОУИС-ийн багш
68.	П.Нарантуяа	Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын мэргэжилтэн
69.	Б. Ганбаатар	Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч
70.	Ж. Батзоригт	Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Дэд ерөнхийлөгч
71.	Д. Батсүх	Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн
72.	М. Алтан-Өлзий	Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч
73.	О. Батсүх	Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч
74.	П. Цэвээн	Хүүхдийн эрхийн үндэсний төвийн тэргүүн
75.	О.Сэлэнгэ	Монголын сурагчдын холбооны тэргүүн
76.	Н.Ууганбаяр	Хүүхдийн оролцооны байгууллагуудын сүлжээний зохицуулагч
77.	Г. Ойнбаяр	Өнөр бүл төвийн ахлах нийгмийн ажилтан
78.	Х.Баавгай	Хүүхдийн оролцооны байгууллагуудын сүлжээ
79.	Б. Мөнхжаргал	Сургуулийн Нийгмийн ажилтын нийгэмлэг

80.	С.Дондов	Иргэдэд туслах хүний эрхийн төв
81.	М.Цасчихэр	Эрчүүд – Эрүүл гэр бүл төв
82.	Б.Сувд	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
83.	Н.Арвинтариа	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
84.	Д.Санчир	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
85.	Хана Бводска	Чехийн Элчин Сайдын Яам
86.	Домонкос Гюнге	Унгарын Элчин Сайдын Яам
87.	Элизабет Барсак	Францын Элчин Сайдын Яам
88.	Сузана Жанкечова	Олон Улсын Шилжилт Хөдөлгөөн Байгууллага
89.	Аня Курта	Германы Элчин Сайдын Яам
90.	Хэйди Хершед	АНУ-ын Элчин Сайдын Яам
91.	Шоун Фаст	АНУ-ын Элчин Сайдын Яам
92.	М. Хоролсүрэн	АНУ-ын Элчин Сайдын Яам
93.	О. Алтангэрэл	Өмгөөлөгч
94.	Д. Оросоо	УИХ дахь АН-ын бүлгийн хуулийн зөвлөх
95.	Б. Хишигсайхан	Нээлттэй Нийгэм Форум
96.	Ж. Оюунтунгалаг	Нийслэлийн Шүүх
97.	Д. Баярсайхан	Нийслэлийн Ерөнхий Шүүхийн Тамгийн Газрын дарга
98.	О. Алтансүх	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
99.	Э.Батбаяр	Өмгөөлөгч
100.	Б.Батхуяг	УИХ- дахь Ардчилсан намын хуулийн зөвлөх
101.	Ш. Отгонбаяр	МУИС-ын оюутан

ХАВСРАЛТ # 2 ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Европын Холбоо болон Монгол улс эрүүгийн эрх зүйн тогтолцооны шинэчлэлд хамтран ажиллана

2018 оны 1 дүгээр сарын 15

Улаанбаатар хот

2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Европын Холбоо болон Монгол Улсын Засгийн газар хамтран “Монгол улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоо ба хүний эрхийн хэрэгжилт” сэдэвт бага хурлыг Европын Холбооны санхүүжилтээр зохион байгуулах гэж байна. Европын Холбоо болон Монгол улсын хамтын ажиллагааны чухал хөшүүрэг болсон Монгол улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд олон улсын хүний эрхийн хэм хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд энэхүү үйл ажиллагаа зохион байгуулагдаж буй билээ. Европын Холбооноос 2016-2020 онд хэрэгжүүлэх Хүний эрх ба Ардчилалын стратеги баримт бичгийн хүрээнд тус улсад байгуулагдаж буй суурин төлөөлөгчийн газрын тэргүүлэх чиглэлийн нэг нь хууль дээдлэх ёсыг хангах үйл ажиллагаага юм. “ Монгол улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоо ба хүний эрхийн хэрэгжилт” сэдэвт бага хурлыг Европын Холбооноос Монгол улсад хүний эрхийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх төсөл, Гадаад Харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран зохион байгууллаа.

Тус бага хуралд Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагуудын удирдлага, төлөөлөл оролцох бөгөөд уг хурлыг нээж , Монгол улсын Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга Д. Даваасүрэн үг хэлнэ. Хурлын үйл ажиллагаанд олон улсын болон үндэсний хүний эрхийн шинжээчид оролцож, тус улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоог төгөлдөржүүлэх, олон улсын хүний эрхийн зарчим, стандартыг хэрэгжүүлэхэд түлхэц болохуйц санаа оноо, зөвлөмжүүдийг хэлэлцүүлнэ.

2017 оны 7 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчлэлт, өөрчлөлтүүд хүний эрхийн хангах боломжийг нээж буй хэдий ч амьдрал дээр бэрхшээл, сорилтууд байсаар байгаа билээ. “Энэхүү бага хурлын үйл ажиллагаа нь эрүүгийн эрх зүйн тогтолцоог хуулийн өөрчлөлтөөр хийхээс гадна бодлогын түвшинд, өргөн хүрээнд хэрэгжүүлэх боломжийг нээж буй юм” хэмээн Европын холбооны Монгол улс дахь Суурин төлөөлөгчийн газарын хэргийг түр хамаарагч ноён Марко Ферри хэллээ.

Эрүүгийн болон эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн чухал өөрчлөлтүүд, ялангуяа хэргийн зүйлчлэл, ялын бодлогод орсон өөрчлөлтүүд, хэргийг мөрдөн шалгах үйл явцад хүний эрхийг хангах, гэрч хохирогчийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллийн болон бусад жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчидтой холбоотой хэргийг мөрдөх, насанд хүрээгүй хүүхдийн хэрэг эрхлэх асуудал зэрэг сэдвүүдэд хурал анхаарлаа хандуулна.

“Энэхүү хурлаас гарах тайлан, зөвлөмж нь Монгол улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд олон улсын хүний эрхийн стандартын дагуу хүний эрхийг хангах үйл ажиллагаанд болон Европын холбоо, Монгол улсын хүний эрхийн талаарх хамтын ажиллагаа, яриа хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд чухал нөлөөгөө үзүүлнэ гэж үзэж байна.

Европын холбооны зүгээс ийм төрлийн хүний эрхийн гурван цуврал бага хурал зохион байгуулахаас гадна тус улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцуудыг орчуулах, хэвлүүлэхэд туслалцаа үзүүлэх юм. “Бидний дэмжлэг, үйл ажиллагаа үүгээр зогсохгүй, мөн Европын Холбооны улсуудад хоёр удаагийн шинжээчийн түвшний аялалыг зохион байгуулахад туслалцаа үзүүлж ажиллана” гэж ноён Марко Ферри өгүүллээ. Эдгээр аялал нь эрүүгийн багц хуулиудыг олон улсын хүний эрхийн стандарттай нийцүүлдэн хэрэгжүүлэх прокурорын байгууллагын боловсон хүчинийг чадавхжуулахад түлхэц үзүүлнэ. Мөн УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн хүний эрхийн сургалтын агуулга, боловсон хүчиний чадавхийг дээшлүүлэхэд хамтран ажиллана.

